83.0% (58.1 оноо)

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2020 оны 100 тоот тушаалын*
*4 дүгээр хавсралт*

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ**
**САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН**
**САНХҮҮ, ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин /2024 он/ | Зорилтот түвшин /2025 онд хүрэх/ | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах албан хаагч | Хэрэгжилт | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1.1 Гэр бүл, хүн амын онцлогт нийцсэн бодлого хэрэгжүүлэх | | | | | | | | |
| 1 | Эмнэлэг хяналтын комиссын ажиллах журам, гишүүдэд олгох урамшууллын хэмжээг тооцоолох | Урамшууллын хэмжээ | /-/ | Урамшууллын тооцоог хийх | I-IV улирал | ЭМЭЗСБТХ мэргэжилтэн | Эрүүл мэндийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.22-дах хэсэгт заасан Эмнэлэг хяналтын комисс ажиллах журам, гишүүдэд олгох урамшууллын хэмжээг тогтоох журмын төслийг ЭТБГ-аас боловсруулсан бөгөөд урамшуулал олгоход шаардагдах төсвийн тооцоо, хэрэгцээ шаардлага, төсөвт үзүүлэх нөлөөлөл, санхүүжүүлэх эх үүсвэрийн судалгааг гаргасан. Нийслэлийн хэмжээнд нийт 50 амбулатори ажилладаг бөгөөд эмнэлэг хяналтын комисст 4 хүн ажиллаж 7 хоног бүр хуралдаж шийдвэр гаргадаг хэмээн тооцоход 216.0 сая төгрөгийн хэрэгцээ шаардлага урьдчилсан байдлаар гарсан. | 30<br>30 |
| 2.1.3 Нийгмийн баталгаа | | | | | | | | |
| 2.1.3.1 Үндэсний баялгийн сангийн тогтолцоог бэхжүүлж, Үндэсний баялгийн сангаар дамжуулан эрүүл мэнд, боловсрол, орон сууцжуулалт, хуримтлалын хөтөлбөрийг хэрэгжүүлж, “E-mongolia” платформоор дамжуулан иргэн бүрт хуримтлалын данс нээнэ | | | | | | | | |
| 2 | ЗГҮАХ 2.1.3.1.251<br>Үндэсний баялгийн сангийн нэрийн дансан дахь хуримтлалыг эрүүл мэнд, боловсрол, орон сууцны зориулалтаар зарцуулах боломжийг бүрдүүлнэ. | Хүсэлтийг шийдвэрлэсэн хувь | /-/ | Журмын дагуу шийддэрлэсэн байна. | I-IV улирал | ЭМЭЗСБТХ мэргэжилтэн | Үндэсний баялгийн сангийн нэрийн дансан дахь хуримтлалыг эрүүл мэнд, боловсрол, орон сууцны зориулалтаар зарцуулах хүсэлт ирээгүй байна. | 100<br>Хугацаа болоогүй |
| 3 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагчдад ур чадварын | Журам | /-/ | Шалгуур үзүүлэлт боловсру | I-IV улирал | Т.Болорчимэг | Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтын 4 дэх заалтын дагуу Эрүүл мэндийн салбарын | 100<br>100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин /2024 он/ | Зорилтот түвшин /2025 онд хүрэх/ | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах албан хаагч | Хэрэгжилт | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт боловсруулж батлуулна | | | улж, санал авсан байна | | | төрийн үйлчилгээний албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлтийг СТГ-ын Салбарын хүний нөөцийн хөгжлийн хэлтэстэй хамтран боловсруулж, ТНБД-ын 2022 оны А/61 дүгээр тушаалаар батлагдсан "Эрүүл мэндийн сайдын тушаалд санал авах хуудас"-ын дагуу 7 газар, 2 хэлтэс болон ТНБД-аас санал аваад байна. Шалгуурыг Эрүүл мэндийн байгууллагын удирдах ажилтан, эмнэлгийн мэргэжилтэн болон эмнэлгийн бусад мэргэжилтэн гэсэн ангиллаар тус бүрт нь 6-8 шалгуур үзүүлэлт байхаар боловсруулсан болно. | |
| 2.3.1 Нийгмийн эрүүл мэнд | | | | | | | | |
| 4 | ЗГҮАХ 2.3.1.1.388<br>Нийгмийн эрүүл мэндийн асуудал хариуцсан үндэсний төв байгуулна | Төсвийн тооцоолол | 15 | Холбогдох төсвийн тооцоо хийсэн байна | I-IV улирал | НЭМТҮСТХХ мэргэжилтэн | Эрүүл мэндийн сайдын 2025 оны "Эрх шилжүүлэх тухай" А/109, "Төсөв баталж, эрх шилжүүлэх тухай" А/138, А/142, А/169, А/196, А/202 дугаар тушаалуудыг батлуулж холбогдох байгуулллагуудад нь хүргүүлэн ажилласан. | 100<br>100 |
| 5 | ЗГҮАХ 2.3.1.1.389<br>Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед удирдлага зохион байгуулалтын шуурхай байдал, мэдээлэл судалгаагаар хангах Удирдлагын нэгж байгуулах | Төсвийн тооцоолол | 15 | Холбогдох төсвийн тооцоо хийсэн байна | I-IV улирал | НЭМТҮСТХХ мэргэжилтэн | - Улаанбурхан өвчнөөс сэргийлэх бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэхтэй холбоотой 5 хүртэлх насны хүүхийн нөхөн дархлаажуулалтынг зохион байгуулахад 146.3 сая төгрөг зарцуулах тухай Эрүүл мэндийн сайдын 2025 оны 04 сарын 18-ны өдрийн А/142 дугаар тушаалыг батлуулан ажиллаж байна.<br>- Улаанбурхан өвчин дэгдсэнтэй холбоотой улаанбурхан өвчнөөс сэргийлэх бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэх, ши нжилгээ хийхэд шаардлагатай урвалж, оношлуур, дагалдах хэрэгсэл худалдан авахад 386.8 сая төгрөг зарцуулах тухай Эрүүл мэндийн сайдын 2025 оны 05 сарын 15-ны өдрийн | 100<br>30 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин /2024 он/ | Зорилтот түвшин /2025 онд хүрэх/ | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах албан хаагч | Хэрэгжилт | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | А/196 дугаар тушаалыг батлуулан ажиллаж байна. | |
| 2.3.2.3 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгож, ЭМД санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, зарцуулалтыг оновчтой болгон, иргэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авахад төлөх төлбөрийг бууруулна | | | | | | | | |
| 6 | ЗГҮАХ 2.3.2.3.409 Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулна. | Хэрэгжилтийн хувь | /-/ | 30 | I-IV улирал | ЭМДБТХХ мэргэжилтэн ЭМЭЗСБТХ мэргэжилтэн | Засгийн газрын 2024 оны 11 сарын 20-ны өдрийн 181 дүгээр тогтоолоор "Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай" батлагдсан. Уг чиглэлийн дагуу өргөн мэдүүлэх хугацаа нь 2026 он гэж заасан тул хугацаа болоогүй байна. | 0 0 |
| 7 | ЗГҮАХ 2.3.2.3.410 Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төрөөс хариуцах иргэдийн болон албан бус салбарын даатгуулагчдын төлөх шимтгэлийн хувь хэмжээг өсгөнө. | Шимтгэлийн хувь хэмжээ | 1 | 2 | I-IV улирал | ЭМДБТТХХ мэгэжилтэн | Монгол Улсын хүн амын өвчлөл, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эрэлт хэрэгцээнээс шалтгаалж жил бүр сангийн батлагдсан төсвөөс тусламж, үйлчилгээ авсан иргэд, даатгуулагчийн нэхэмжлэлийн төлбөр давж байгаа учраас одоо байгаа сангийн хөрөнгийг илүү үр ашигтай хуваарилах, оновчгүй зардлуудыг хасах, давхардлыг арилгах, эх үүсвэрийг нэмэгдүүлэх чиглэлээр зарим арга хэмжээг авч хэрэгжүүлж эхлээд байна. Тухайлбал, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2-т заасан хувиараа хөдөлмөр эрхлэгч, малчин, 0-18 насны хүүхэд, тэтгэврийн болон нийгмийн халамжийн дэмжлэг шаардлагтай иргэд, хуулийн дагуу хүүхдээ асарч байгаа эх/эцэг, их дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалтын төвийн суралцагч, хугацаат цэргийн албан хаагч, ял эдэлж байгаа ялтан зэрэг иргэдийн сард төлөр эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, түүнтэй адилтгах орлогын 2 хувь байхаар; харин Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4-д заасан гадаадын иргэн, харьяалалгүй хүний эрүүл мэндийн | 100 100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин /2024 он/ | Зорилтот түвшин /2025 онд хүрэх/ | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах албан хаагч | Хэрэгжилт | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | даатгалын шимтгэлийн хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, түүнтэй адилтгах орлогын 4 хувь байхаар тус тус тооцоо хийн, төсөл боловсруулж, Засгийн газрын 2025 оны 01 сарын 02-ны өдрийн 02 дугаар тогтоолоор батлуулан, мөрдөж эхлээд байна. | |
| 8 | МУХТЖҮЧ 2.2.5<br>ЗГҮАХ 2.3.2.3<br>МУХТ 3.1.4.1<br>Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих тусламж үйлчилгээний өртөг, төлбөрийн аргыг боловсронгуй болгоно | Шинэчлэгдсэн аргын тоо | 3 | 3 | I-IV улирал | ЭМДБТХХ мэргэжилтэн | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих лавлагаа тусламж, үйлчилгээг 2024 оны байдлаар нийт даатгуулагчийн 60.8 хувь авсан байгаа нь эмнэлгийн тусламж, үйлчилгээний хүртээмж, түүнд эзлэх ЭМД-ын үүрэг оролцоо, санхүүгийн хамгаалалт сайн байгааг харуулж байгаа хэдий ч зарим төрлийн тусламж, үйлчилгээний тоо хэмжээг хязгаарлах, хамтын төлбөрийн оновчтой бодлого хэрэгжүүлэх, шатлал хоорондын уялдаа, тусламж, үйлчилгээний давхардал хуваагдмал байдлыг арилгах, бараа материалын үнийн өсөлттэй уялдуулах, төр болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын хүлээх үүрэг, хариуцлага, тусламж, үйлчилгээний давхардал, зааг ялгааг арилгах зэрэг цогц арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлага үүсэн. Иймд “Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлгийн жагсаалт, төлбөрийн хэмжээ”, “Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх төлбөрийн арга”, “Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах тусламж, үйлчилгээний нэгж тохиолдлыг тооцох, санхүүжүүлэх журам”-ыг тус тус шинэчлэн боловсруулж ЭМДҮЗ-ийн 2025 оны 04 дүгээр | 100<br>100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин /2024 он/ | Зорилтот түвшин /2025 онд хүрэх/ | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах албан хаагч | Хэрэгжилт | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | тогтоолоор батлан 2025 оны 01 сараас хэрэгжүүлэн ажиллаж байна. | |
| 9 | Эрүүл мэндийн сайдын багцын 2024 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу тайлагнана. | Тайлан өгсөн ЭМБ-ын тоо | Нэгдсэн тайлан | Нэгдсэн тайланг СЯ-д хүргүүлсэн байна. | I-II улирал | С.Цогзомаа, Б.Даваажав | Эрүүл мэндийн төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүү, төсвийн гүйцэтгэлийн нэгдсэн тайланд 450 байгууллагын санхүү, төсвийн гүйцэтгэлийн тайлан нэгтгэгдэж, аудитаас бие даан дүгнэлт гаргасан 353 байгууллагаас 289 байгууллага буюу 81.8 хувь нь өөрчлөлтгүй дүгнэлт авч, 97 байгууллага өмнө онуудад алдаа зөрчилгүй ажилласнаар энэ онд түүвэрт хамрагдан, 59 байгууллага хязгаарлалттай дүгнэлт авсан байна. Нийслэлийн Шүд эрүү нүүрний төв, Энэрэл эмнэлэг, Говь-Алтай аймгийн Тонхил сумын ЭМТ сөрөг дүгнэлт авч, Төв аймгийн Баянцагаан сумын ЭМТ, Баян-Өнжүүл сумын ЭМТ-ийн санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөөс тус тус татгалзсан байна. Эрүүл мэндийн салбарын нэгдсэн тайланд хязгаарлалттай дүгнэлт авсан. | 100 |
| 10 | Эрүүл мэндийн сайдын багц, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн хязгаар, 2027-2028 оны дунд хугацааны төсвийн төсөөллийг боловсруулж, Сангийн яаманд хүргүүлнэ. | Санал хүргүүлсэн албан тоот | Албан тоот | СЯ-нд хүргүүлсэн байна. | II улирал | Х.Батчимэг | Эрүүл мэндийн сайдын багц, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг 2025 оны 04 сарын 03-ны өдөр 1а/1618 дугаар албан бичгээр 10 арга хэмжээнд 1,214.6 тэрбум төгрөгийн саналыг нэгтгэн боловсруулж Сангийн яаманд хүргүүлсэн. | 100 |
| 11 | Эрүүл мэндийн сайдын багц, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн төсөл, 2027-2028 оны төсвийн төсөөллийг боловсруулж, Сангийн яаманд санал хүргүүлж, батлуулна. | Санал хүргүүлсэн албан тоот | - | СЯ-нд хүргүүлсэн байна. | III-IV улирал | Х.Батчимэг<br>Э.Баярмаа<br>Ш.Лувсмаа | III улирал тул хугацаа болоогүй | |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин /2024 он/ | Зорилтот түвшин /2025 онд хүрэх/ | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах албан хаагч | Хэрэгжилт | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 12 | УИХ-ын 54-р тогтоол. Эрүүл мэндийн байгууллагуудын сар бүрийн төсвийн гүйцэтгэл, өр авлагын мэдээнд дүн шинжилгээ хийж, улирал тутамд зөвлөмж, чиглэлийг хүргүүлж, төсвийн сахилга батыг сайжруулах | Албан бичгийн огноо дугаар, зөвлөмжийн тоо | зөвлөмж, чиглэл | 2удаа зөвлөмж, чиглэл хүргүүлсэн байна | I-IV улирал | Х.Батчимэг<br>Э.Баярмаа<br>Ш.Лувсмаа | Эрүүл мэндийн байгууллагуудын төсвийн гүйцэтгэлийн тайланд тухай бүр эх үүсвэр дутагдаж буй эсэх, өр төлбөр үүссэн эсэх, авлага барагдсан эсэхэд дүн шинжилгээ хийж нэгжийн удирдлагад тухай бүр танилцуулан ажилласан. Мөн эрүүл мэндийн байгууллагуудад 2025 оны 1а/1176, 1а/1231, 7/1456 дугаар албан бичгээр 3 удаа, аман байдлаар тухай бүр хөтөлбөр зориулалтын дагуу төсвийг захиран зарцуулж, төсвийн сахилга баттай ажиллах, төлөвлөлтийг орлоготой уялдуулан зөв төлөвлөх талаар зөвлөмж чиглэл өгч ажилласан. | 100<br>100 |
| 13 | Тусгай сангийн тухай хуулийн дагуу Эрүүл мэндийг дэмжих сангийн төсвийг зарцуулж, тайлагнана | Эрүүл мэндийг дэмжих сангийн тайлан | - | Журмын дагуу зарцуулж, тайлагнасан байна. | I-IV улирал | Б.Даваажав | Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/89 тушаалаар 17 иргэний гадаад улсад эмчилгээ хийлгэсэн төлбөрийн хөнгөлөлтөд 908.4 сая төгрөгийг олголоо. Мөн 2-р хуралдаанд хэлэлцүүлэх 28 иргэний гадаадад эмчлүүлсэн баримтыг шалган, хурлын материалыг бэлтгэн өгсөн. | 100<br>100 |
| 14 | Эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж үйчилгээний жагсаалт болон журмын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, журам шинэчлэх | Жагсаалт журам | - | Шинэчлэн боловсруулж санал авсан байна | I-IV улирал | Т.Болорчимэг | "Эрүүл мэндийн тухай" хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3-ыг үндэслэн "Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлгийн жагсаалт, төлбөрийн хэмжээ"-г ЭМДҮЗ-ийн 2025 оны 01 сарын 23-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор шинэчлэн тусламж, үйлчилгээний багцад өөрчлөлт орсон тул үүнтэй уялдуулан төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалтыг шинэчлэн боловсруулав. Жагсаалтыг төрийн болон орон нутгийн өмчийн эрүүл мэндийн байгууллагууд болон Лабораторийн мэргэжлийн салбар зөвлөлөөс санал авч судлан дүн шинжилгээ хийсэн. Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/216 дугаар тушаалаар 866 тусламж, үйлчилгээг | 100<br>100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин /2024 он/ | Зорилтот түвшин /2025 онд хүрэх/ | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах албан хаагч | Хэрэгжилт | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | төлбөртэй үзүүлэхээр батлагдсан бол шинэчилсэн жагсаалтаар 1287 байхаар боловсруулсан. Шинэчилсэн жагсаалт, журманд ТНБД-ын 2022 оны А/61 дүгээр тушаалаар батлагдсан "Эрүүл мэндийн сайдын тушаалд санал авах хуудас"-ын дагуу 7 газар, 2 хэлтэс болон ТНБД-аас санал аваад байна. | |
| 15 | Эрүүл мэндийн салбарын 2026-2029 оны стратеги төлөвлөгөөг боловсруулна | Төлөвлөгөө | - | Төсөв санхүү чиглэлээр тусгах төслийг боловсруулна | I-IV улирал | ЭМЭЗСБТХ мэргэжилтэн | Холбогдох газраас Эрүүл мэндийн салбарын 2026-2029 оны стратеги төлөвлөгөөний төслийг боловсруулан ирүүлээгүй байгаа ба 2022-2025 оны төлөвлөгөөнд төсөв санхүү чиглэлийн үйл ажиллагааг судлан холбогдох бодлогын баримт бичигтэй нийцүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж байна. | 30<br>0 |
| 16 | Эрүүл мэндийн салбарын цалин хөлстэй холбоотой мэдээ мэдээлэлд холбогдох тооцоо, судалгаа хийх, шаардлагатай санал зөвлөмжийг боловсруулах | Санал зөвлөмж | | Санал зөвлөмж боловсруулсан байна | I-IV улирал | Т.Болорчимэг | -Төрийн үйлчилгээний салбарын албан тушаалын зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалтыг Засгийн газрын 2023 оны 240 дүгээр тогтоолоор баталсан ба "эмнэлгийн физикч", "туяа эмчилгээний техникч" нарын албан тушаал нь жагсаалтад байдаггүй тул "эмнэлгийн физикч" албан тушаалыг ТҮЭМ-7 ангилалд; "туяа эмчилгээний техникч" албан тушаалыг ТҮЭМ-5 ангилалд шинээр нэмж оруулахаар холбогдох үндэслэл, тооцоог боловсруулан Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд 2025 оны 04 сарын 15-ны өдрийн 1а/1852 тоот албан бичгээр санал хүргүүлсэн.<br>-Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалтыг Засгийн газрын 2022 оны 487 дугаар тогтоолоор баталсан ба Аймгийн Эрүүл мэндийн газрын "Эрүүл мэндийн эдийн засаг, төсвийн төлөвлөлт, хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн"-ний албан тушаалыг ТЗ-9 ангиллаас | 100<br>100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин /2024 он/ | Зорилтот түвшин /2025 онд хүрэх/ | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах албан хаагч | Хэрэгжилт | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | өөрчилж ТЗ-7 ангилалд оруулахаар холбогдох үндэслэл, тооцоог боловсруулан Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд 2025 огы 04 сарын 15-ны өдрийн 1а/1852 тоотоор санал хүргүүлсэн.<br>-Цалин хөлс, нэмэгдэл, урамшууллын талаар Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, “Эрүүл мэндийн салбарын 2024-2026 оны хамтын хэлэлцээр”, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол, 2019 оны 05 дугаар тогтоол, 2024 оны 82 дугаар тогтоол, 2024 оны 238 дугаар тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/544 дүгээр тушаал, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/221 дугаар тушаал зэрэг хүчин төгөлдөр мөрдөгдөж буй эрх зүйн баримт бичгийг баримтлан ажиллах тухай чиглэл, зөвлөмжийг бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудад 2025 оны 04 сарын 29-ний өдрийн 1а/2171 тоот албан бичгээр хүргүүлсэн. | |
| 17 | Урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт туссан эрүүл мэндийн эдийн засаг, санхүүгийн чиглэлээрх зорилт, арга хэмжээг нэгтгэх, тайлагнах | Тайлан | - | Тайлан нэгтгэн холбогдох нэгжид хүргэгдсэн байна | I-IV улирал | Т.Болорчимэг | 2025 оны эхний хагас жилд дараах бодлогын баримт бичгийн хэрэгжилт, тайлан мэдээг бэлтгэн холбогдох байгууллага болон Эрүүл мэндийн яамны холбогдох газар, хэлтэст хүргүүлсэн байна. Үүнд:<br>-Үндэсний аудитын газарт Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилттэй холбоотой 2023, 2024 оны үнэлгээний тайланг хүргүүлсэн. 2025 оны 02 сарын 11-ний өдрийн 7/769 тоот албан бичиг,<br>-ТЗУГ-с ирүүлсэн Гэр бүлийг дэмжих тухай анхдагч хуулийн төсөлд санал боловсруулж Дотоод мемо №216-аар хүргүүлсэн.<br>-Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд туссан санхүү, эдийн засгийн | 100<br>100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин /2024 он/ | Зорилтот түвшин /2025 онд хүрэх/ | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах албан хаагч | Хэрэгжилт | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | чиглэлийн зорилт, арга хэмжээг тайлагнан ХШҮДАГ-т хүргүүлэв.<br>-Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг гаргаж ХШҮДАГ-т хүргүүлэв.<br>-Эрүүл мэндийн яамны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний Санхүү, даатгалын чиглэлийн арга хэмжээний хэрэгжилтийн тайланг гаргаж ТЗУГ-т хүргүүлэв. | |
| 18 | Эрүүл мэндийн тухай хуулийн 29.2, 29.5-д заасан мөнгөн тэтгэмжийн бодлого, хэрэгжилтийг зохион байгуулах, нэгтгэх, тайлагнах | Мөнгөн тэтгэмж | - | Мөнгөн тэтгэмж олгогдсон байна | I-IV улирал | Э.Баярмаа, Ш.Лувсмаа | 2025 оны эхний хагас жилийн байдлаар Төрийн албаны тухай хууль болон Эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 заалтын дагуу эмнэлгийн мэргэжилтэн, нийгмийн эрүүл мэндийн ажилтан, эрүүл мэндийн бусад ажилтанд тэтгэвэрт гарахад нэг удаагийн мөнгөн тэтгэмжид 3.8 тэрбум төгрөг, харин мөн хуулийн 29.5 дахь заалтын дагуу Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд болон Аймаг дахь төрийн болон орон нутгийн өмчит эрүүл мэндийн байгууллагад тасралтгүй ажиллаж байгаа албан хаагчдад 7.2 тэрбум төгрөгийг олгоод байна. | 100<br>100 |
| 19 | Эрүүл мэндийн сайдын багцын дүнгээр тайлагнадаг төсөв, санхүүгийн мэдээллийг Шилэн дансны тухай хуулийн дагуу хугацаанд нь тайлагнах, мэдээллэх | Журмын дагуу байршсан мэдээллийн тоо | - | Шилэн дансны цахим хуудаст мэдээлсэн байна. | I-IV улирал | С.Цогзолмаа Б.Даваажав | Эрүүл мэндийн салбарын нэгдсэн төсвийн үйл ажиллагаатай холбоотойгоор:<br>1.Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэл /сар бүр/ – 6 удаа,<br>2.Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, түүний хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлтийн төлөвлөгөө /жил бүр/ – 1 удаа,<br>3.Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, түүний хүрэх үрдүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлт, биелэлт /жил бүр/ – Хугацаа болоогүй, | 100<br>100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин /2024 он/ | Зорилтот түвшин /2025 онд хүрэх/ | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах албан хаагч | Хэрэгжилт | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 4.Байгууллагын батлагдсан төсөв /жил бүр/– 1 удаа,<br>5.Дараа жилийн төсвийн төсөл, Хугацаа болоогүй /жил бүр/ – Хугацаа болоогүй,<br>6.Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэл /жил/ – 1 удаа,<br>7.Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт /Тухай бүр/ – 6 удаа,<br>8.Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт /Тухай бүр/ – 6 удаа,<br>буюу 21 удаа Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хуулийн хугацаанд байршуулан ажилласан.<br>Хугацаа хоцроосон мэдээлэл байхгүй байна. | |
| 20 | Эрүүл мэндийн байгууллагуудын төлбөр тооцооны гүйлгээ, хяналт, баримтын бүрдүүлбэр, төрийн сангийн үйл ажиллагааг зохион байгуулах | Төлбөр тооцооны тоо | - | ЭМБ-ын гүйлгээ хийгдсэн байна. | I-IV улирал | О.Баяржаргал<br>Д.Гантуяа | 2025 оны 01 сарын 01-ний өдрөөс 06 сарын 10-ны өдрийн байдлаар Эрүүл мэндийн яам болон харьяа 21 байгууллага, ЭМДаатгалын сан, ЭМДэмжих сангийн нийт 47 дансны нийт 2.1 их наяд төгрөгийн 39,212 ширхэг зарлагын гүйлгээг Төрийн сангийн үйл ажиллагааны журам болон бусад хууль, дүрмийн дагуу холбогдох анхан шатны баримт, батлагдсан төсвийн хуваарь, эдийн засгийн ангиллын дагуу хянаж, бүрдэл болсон зарлагын гүйлгээг цахим системээр хийсэн. | 100<br>100 |
| 21 | Эрүүл мэндийн сайдын багцын Улсын төсвөөс хариуцах эмнэлгийн тусламж үйлчилгээний санхүүжилтийг холбогдох тушаал, шийдвэр, гэрээнд үндэслэн санхүүжүүлэх, тайлагнах | Хөтөлбөр, зориулалтын тоо, зарцуулсан мөнгөн дүн | - | Зориулалтын дагуу санхүүжилт олгогдсон байна. | I-IV улирал | С.Цогзолмаа<br>Б.Даваажав | Эрүүл мэндийн сайдын багцын Улсын төсвөөс хариуцах эмнэлгийн тусламж, үйлчилгээний санхүүжилт данснаас холбогдох тушаал, шийдвэр, гэрээнд үндэслэн эхний хагас жилийн байдлаар 742,3 тэрбум төгрөгийн гүйлгээг анхан шатны баримтын бүрдлийг бүрдүүлэн санхүүжүүллээ. Үүнд ЭМД-аар дамжуулан гүйцэтгэлээр олгох санхүүжилт, төрөөс | 100<br>100 |

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин /2024 он/ | Зорилтот түвшин /2025 онд хүрэх/ | Хугацаа /I-IV улирал/ | Хариуцах албан хаагч | Хэрэгжилт | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | төрийн албан хаагчид тэтгэвэрт гарахад олгох мөнгөн тэтгэмж, Халдварт өвчин судлалын үндэсний төв, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд олгох дэмжлэг санхүүжилт, НҮБ-аар дамжуулан худалдан авах вакцины санхүүжилт зэрэг гүйлгээнүүд багтана. | |
| 22 | Эрүүл мэндийн салбарт хэрэгжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийг холбогдох гэрээнд үндэслэн гүйцэтгэлийн дагуу санхүүжүүлэх, тайлагнах | Хөтөлбөр, зориулалтын тоо, зарцуулсан мөнгөн дүн | - | Зориулалтын дагуу санхүүжилт олгогдсон байна. | I-IV улирал | С.Цогзолмаа<br>Б.Даваажав | 2022-2024 онуудад улсын комисс хүлээн авсан 13 барилга, их засварын ажлын баримтын бүрдлийг ханган албан бичгээр Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 56, 86, 126 дугаар тогтоолоор 12 барилгыг ашиглагч байгууллагад шилжүүллээ.<br>Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 6 барилга, 1 их засвар нийт 7 арга хэмжээний 10 гүйцэтгэлийг хянан 13.9 тэрбум төгрөгийг гүйцэтгэгч байгууллагад шилжүүллээ. Барьцаа данснаас 13 арга хэмжээний гүйцэтгэл болон 13 төслийн байршуулсан барьцаа чөлөөлөн 11.0 тэрбум төгрөгийг шилжүүлсэн. Техник хяналтын данснаас гэрээт ажилтны 5 сарын цалинг тооцон олгож, ХХОАТ, НДШ-ийн гүйлгээг хийлээ. Мөн аудитын төлбөрийн актаар тогтоогдсон 2020-2022 оны техник хяналтын үлдэгдэл 160.0 сая төгрөгийг шилжүүллээ. | 100<br>100 |
| | | | | | | | | 88,5 |

---oOo---

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Арга хэмжээ 1. Монгол бичгийн сургалтад хамрагдах | Сургалтад хамрагдсан гэрчилгээ | - | Сургалтад хамрагдсан байна. | Удирдлагын академиас төрийн албан хаагчдад зохион байгуулсан “Монгол бичиг” анхан шатны цахим сургалтад 2025 оны 06 дугаар сард хамрагдаж, гэрчилгээ (№734366) авсан. | 2025.06 | **100.0** |

Төлөвлөгөөг үнэлсэн: ***Төсвийн шууд захирагч***

Төрийн нарийн бичгийн дарга ........................................................................ /Д.Очирбат/
(албан тушаал) (гарын үсэг)
.............................. (огноо)

Тэмдэг

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн: Үнэлгээний багийн ахлагч
Нийгмийн эрүүл мэндийн бодлогын
газрын Халдварт өвчний хэлтсийн дарга ........................................................... /Д.Баярболд/
(албан тушаал) (гарын үсэг)

.............................. (огноо)

Тайлагнасан: Нэгжийн дарга

Санхүү, эдийн засгийн бодлогын газрын ........................................................... /Л.Мөнхцэцэг/
Санхүү, даатгалын хэлтсийн дарга
(албан тушаал) (гарын үсэг)

......................... (огноо)

УДИРДЛАГЫН
АКАДЕМИ

# ҮНЭМЛЭХ

№ 734366

**Лхагважав овогтой Мөнхцэцэг**

**“Монгол бичиг” анхан шат**

ЦАХИМ СУРГАЛТАД АМЖИЛТТАЙ ХАМРАГДСАН ТУЛ ЭНЭХҮҮ ҮНЭМЛЭХИЙГ ОЛГОВ.

**Д.СҮРЭНЧИМЭГ**
*Доктор, дэд профессор*
Удирдлагын академийн
захирал

**Д.БАЙГАЛ**
*Доктор, профессор*
Удирдлагын академийн
Төрийн албаны сургуулийн захирал

2025.9